



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2022 төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна.
Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Нийгмийн даатгалын санд 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид зарцуулах төсвийн эрх хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч эргэн төлөх төлбөрийн тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацаа.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2022 оны төсвийн жилд нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр бий болгож

хуримтлуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжид зориулан хөрөнгө зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

--- оОо ---